



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

**“Дээлтэй Монгол -2012” наадам
зохион байгуулах тухай**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 06 сарын 19 –ний өдрийн А/444 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улаанбаатар хотын аялал жуулчлал -2015” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын идэвхитэй улирал эхэлж байгаатай холбогдуулан Монголын нүүдэлчин ард түмний соёл иргэншил, ёс заншлын өв урлагийг гадаад, дотоодын жуулчдад сурталчилан таниулах, Үндэсний дээл хувцсыг дэлхийн өв соёлд бүртгүүлэх, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчилах зорилгоор “Дээлтэй Монгол -2012” наадам арга хэмжээг 2012 оны 07 сарын 13–ны өдөр Д.Сүхбаатрын талбайд зохион байгуулахыг тус газрын эвент хариуцсан мэргэжилтэн /Г.Нямцогт/ -д үүрэг болгосугай.

2. “Дээлтэй Монгол-2012” наадам арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардал 6.000.000 /зургаан сая/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2012 оны 04 сарын 12-ны өдрийн А/251 тоот захирамжаар батлагдсан Үндсэний болон нийслэлийн дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/ -д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

1150500